



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" УТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2023/14/НА-СТА-ААТҮГ

|                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                                       |
|--------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Алтай хот<br>2021 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр<br>Утас: 70483413 Цахим хаяг:<br>tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 70484055 Цахим хаяг:<br>erdenechimegd@audit.gov.mn<br>Ахлах аудитор Ж.Бүжинханд<br>Утас: 99177546 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn |
|--------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2022.03.14

№

109

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" УТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" УТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар түрээсийн төлбөрийг дутуу төвлөрүүлсэн, өглөгийг барагдуулаагүй, орлогыг мөнгөн сууриар бүртгэсэн, хөрөнгийн тооллогын комисс томилоогүй, тооллогын илтгэх хуудас байхгүй, агуулахын бүртгэл хөтлөөгүй, орлогын төлөвлөгөөг тасалсан зэрэг 191.1 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Энэ хуулиар байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

### Аудитын гол асуудал

Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" УТҮГ-ын 2022

0702000244

оны орлого, зардлыг 437.3 сая төгрөгөөр буюу цэвэр ашиг, алдагдалгүй төлөвлөгөөг баталсан. Энэ тогтоолын хэрэгжилтийг дүгнээгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

|                                                | Үзүүлэлт                                          | 2021.12.31         | 2022.12.31         |
|------------------------------------------------|---------------------------------------------------|--------------------|--------------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |                                                   |                    |                    |
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 6,234.0            | 14,969.0           |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 4,229,878.2        | 4,179,070.6        |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>4,236,112.2</b> | <b>4,194,039.6</b> |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             |                    | 51,461.8           |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 4,236,112.2        | 4,142,577.8        |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>4,236,112.2</b> | <b>4,194,039.6</b> |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>            |                                                   |                    |                    |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 177,091.6          | 401,694.6          |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 140,524.5          | 495,228.9          |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>36,567.1</b>    | <b>-93,534.3</b>   |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        |                    | 0.0                |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>36,567.1</b>    | <b>-93,534.3</b>   |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   |                    |                    |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        |                    | 0.0                |
|                                                | Өмчид гарсан өөрчлөлт                             | 4,199,545.0        | 4,236,112.2        |
|                                                | Тайлант оны үр дүн                                | 36,567.1           | -93,534.3          |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>4,236,112.2</b> | <b>4,142,577.8</b> |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                    |                    |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 174,739.2          | 380,274.6          |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 136,157.0          | 341,049.9          |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>38,582.2</b>    | <b>39,224.7</b>    |
|                                                | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <b>-38,177.5</b>   | <b>-38,792.2</b>   |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 | <b>0.0</b>         | <b>0.0</b>         |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>404.7</b>       | <b>837.3</b>       |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  |                    | 404.7              |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 404.7              | 837.3              |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ</b>          |                                                   |                    |                    |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          |                    |                    |
|                                                | Урсгал зардал                                     |                    |                    |
|                                                | Хөрөнгийн зардал                                  |                    |                    |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             |                    |                    |
|                                                | Улсын төсвөөс санхүүжих                           |                    |                    |
|                                                | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас             |                    |                    |
|                                                | Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл                         |                    |                    |

Гурав. Аудитын илрүүлэлт:

### 3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 150.9 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитаар залруулсан. Үүнд:

<sup>1</sup> Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

**Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Мөнгөн гүйлгээний тайланд зардлыг 2.0 сая төгрөгөөр, үр дүнгийн тайланд аж ахуйн материал худалдан авах зардлыг 47.8 сая төгрөгөөр, барилга байгууламжийн элэгдлийг 101.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн алдаа гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 194.9 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 0.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 194.0 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 8 заалт албан шаардлага, хуулийн хэрэгжилт хангах 1 заалт зөвлөмж хүргүүлсэн.

### **3.1 Төлбөрийн акт**

- ✓ Түрээслэгчээр гэрээнд заасны дагуу 40 хувь болох 0.5 сая төгрөгийг байгууллагын дансанд, Өмч хувьчлалын орлогын дансанд 60 хувь болох 0.3 сая төгрөгийг төлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"; Орон нутгийн өмчийн гэрээний 10.3-т заасан төлбөр төлөх график"-г зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна..

### **3.2 Албан шаардлага**

- ✓ 2022 оны 07-11 сард ажилтны илүү цагийг ажилласан өдөрт шилжүүлж 0.4 сая төгрөгийн цалин бодсон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Байгууллагын бүтэц орон тоог үзэхэд эмч 1 дутуу, харуул 1 орон тоогоор илүү ажиллаж байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох; Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 107 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 107 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" улсын төсөвт үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц"-д бичиг хэргийн ажилтан, нярвын ажлыг 1 орон тоогоор ажиллуулахаар баталсан. Гэтэл нярвын ажлыг хавсарсны нэмэгдлийг 40 хувиар буюу 2.2 сая төгрөгийг 2022 оны 03 сараар олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- өдрийн 107 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Тайлант хугацаанд 51.5 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх"; гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
  - ✓ Байр түрээсийн 6.8 сая төгрөгийн, бассейны 71.6 сая төгрөгийн орлогыг аккурэл сууриар бүртгээгүй, мөнгөн сууриар шууд бичилт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө" заалт, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах, УСНББОУС1 "Үнэн зөв ба толилуулга, нийцсэн байдал" гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
  - ✓ Нэгдсэн халаалтад холбогдсон боловч дулааны тоолуур ашиглаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т "нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах; гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
  - ✓ Хөрөнгийн тооллогын комисс томилоогүй, тооллогын илтгэх хуудас байхгүй, агуулахын бүртгэл хөтлөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ": 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
  - ✓ Аж ахуйн нэгж, байгууллагаас 3.7 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад



дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний гүйцэтгэлийг үзэхэд бассейны орлого 56.0 сая төгрөгөөр, түрээсийн орлого 1.7 сая төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"; Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 106 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс түүвэрчилж үзэхэд 68.2 сая төгрөгийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 10 шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.


Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

| / сая төгрөгөөр/                               |            |       |                                   |     |                          |       |            |       |              |     |         |     |
|------------------------------------------------|------------|-------|-----------------------------------|-----|--------------------------|-------|------------|-------|--------------|-----|---------|-----|
| Байгууллагын нэр                               | Нийт алдаа |       | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |       | Үүнээс     |       |              |     | Зөвлөмж |     |
|                                                |            |       |                                   |     |                          |       | Залруулсан |       | Залруулаагүй |     |         |     |
|                                                | Тоо        | Дүн   | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн   | Тоо        | Дүн   | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" УТҮГ | 3          | 150.9 | -                                 | -   | 3                        | 150.9 | 3          | 150.9 | -            | -   | -       | -   |
| Дүн                                            | 3          | 150.9 | -                                 | -   | 3                        | 150.9 | 3          | 150.9 | -            | -   | -       | -   |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл



/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр                               | Нийт зөрчил |       | Үүнээс        |     |                 |       |         |     |                                      |                     |                                                 |     |
|------------------------------------------------|-------------|-------|---------------|-----|-----------------|-------|---------|-----|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|-----|
|                                                |             |       | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |       | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|                                                | Тоо         | Дүн   | Тоо           | Дүн | Тоо             | Дүн   | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн |
| "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" УТҮГ | 9           | 191.2 | 2             | 0.8 | 7               | 190.3 | -       | -   |                                      |                     | -                                               | -   |
| Дүн                                            | 9           | 191.2 | 2             | 0.8 | 7               | 190.3 | -       | -   | 1                                    | 1                   | -                                               | -   |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр            | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |  |
|------------------------------------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--|
|                                                |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |  |
|                                                | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |  |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил       |             |     |               |     |                 |     |         |     |  |
| "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" УТҮГ | 3           | 3.7 | -             | -   | 2               | 3.7 | 1       |     |  |
| Нийт дүн                                       | 3           | 3.7 | -             | -   | 2               | 3.7 | 1       |     |  |

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Өөрчлөлтгүй             | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ТШЗ                         | 1                        | 1                           | -                  | -               | -                       | 1              | -     | -                          |
|   | НИЙТ                        | 1                        | 1                           | -                  | -               | -                       | 1              | -     | -                          |